



## НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

### Иргэдтэй хийх уулзалтын хуваарийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтад нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ыг мөрдөж ажиллахыг удирдлагуудад үүрэг болгосугай.

2. Дүүргийн удирдлагын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын даргын иргэдтэй хийх уулзалтын хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Иргэдтэй хийх уулзалтын хуваарь шинэчлэн батлагдаж байгаатай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Нарангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.СУМЪЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын  
2021 оны 02 дүгээр сарын 08-ны өдрийн  
А/53 дугаар захирамжийн хавсралт

УДИРДЛАГУУДЫН ИРГЭД ХҮЛЭЭЖ АВАХ ХУВААРЬ

2021 оны 02 дугаар сарын 08

Улаанбаатар хот

№	Иргэд хүлээн авах удирдлагын нэр, албан тушаал	Иргэд хүлээн авах хугацаа	Холбогдох утасны дугаар	Уулзалтын байр	Уулзалтыг зохион байгуулах албан хаагч
1	Ө.Сумъяабаатар Засаг дарга	Пүрэв гараг 14.00-16.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн
2	Г.Нарангэрэл Засаг даргын орлогч	Баасан гараг 10.00-12.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн
3	Д.Мөнхбаатар Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч	Даваа гараг 10.00-12.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн
4	Д.Жаргалсүрэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч	Лхагва гараг 14.00-16.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн
5	Б.Нарангэрэл Тамгын газрын дарга	Лхагва гараг 10.00-12.00	70121609	Иргэд хүлээн авах танхим	Д.Гэрэлээ Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн